

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2022 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагууд нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг бичгээр, амаар, цахим сүлжээ, санал хүсэлтийн хайрцаг, нээлттэй 70543434 дугаарын нээлттэй утсаар хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, бүртгэл хяналтын картаар шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин, шийдвэрлэж байна.

Аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтэд тусгагдсан асуудлыг ангилан авч үзвэл:

- Гэр хүсэх тухай-1
- Дэмжлэг хүссэн-1
- Газрын асуудлаар-3
- Тусламж хүсэх тухай-1
- Хогтой холбоотой асуудлаар-1

Аймгийн Засаг даргад гэр хүсэх тухай 1 өргөдөл ирснийг судлан, шийдвэрлэж гэр олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнээс олон улсын тэмцээнд оролцоход дэмжлэг хүссэн өргөдөл ирснийг шийдвэрлэж, 1 сая төгрөгийн дэмжлэг, мөн гадаад улсад яаралтай эмчилгээнд явах 1 иргэний хүсэлтийн дагуу эмчилгээнийх нь зардалд 2 сая төгрөгийн тусламжийг тус тус Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн Засаг даргын нөөц хөрөнгөөс олгоод байна.

Газрын асуудлаар ирүүлсэн 3 өргөдлийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт шилжүүлэн шийдвэрлэсэн.

Сумдын Засаг дарга нарт нийт 43 өргөдөл ирсэн бөгөөд төрлөөр нь ангилбал:

- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох тухай-4 (Судлан үзэж сумын Засаг даргын захирамжаар сран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон)
- Буцалтгүй тусламж хүссэн-7 (Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,8 сая төгрөгийн тусламж үзүүлсэн)
- Худаг, усны асуудлаар-2
- Газрын асуудлаар-15 (сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж шийдвэрлэсэн)
- Тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлт-1 (ажлын хэсэг хуралдаж тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан)
- Бусад асуудлаар-14

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх нээлттэй 425 дугаар анги, Улсын бүртгэлийн хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Шүүхийн шинжилгээний алба, Цагдаагийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар зэрэг байгууллагууд нь дээд шатны

байгууллагатаа өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тайланг хүргүүлдэг тул аймгийн тайланд оруулаагүй боно.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР